




1

Өнгөрөн одоож буй 2023 онд байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хийгдсэн онцлох ажлуудыг танилцуулж байна.

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний орлого бүрдүүлэлт, зарцуулалт, тайлагналт цахим системд шилжүүлж, тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, хуш модны самрыг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдааг холбогдох хууль тогтоомжийн дагуу амжилттай зохион байгуулж, аймгийн хэмжээнд 2,1 тэрбум төгрөг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулагдаж, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого 2,7 тэрбум төгрөг сум орон нутгийн төсөвт орж, орлогын төлөвлөгөө 1,0 тэрбум төгрөгөөр давж биеллээ. (ан амьтны нөөц нөөц ашигласны төлбөрийн орлого 1,1 тэрбум, ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 695,6 сая төгрөг, ус, рашаан ашигласны төлбөрийн орлого 579,5 сая төгрөг)

2023 онд өнгөрсөн жилд





2


Өвөрхангай аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгаа, **2024-2028** онд хэрэгжүүлэх ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлыг мэргэжлийн байгууллага **“АВРАЛЫН ЭРЭЛД”** ХХК-аар гүйцэтгүүлж, аймгийн ИТХ-ын 2023 оны 22/03 дугаар тогтоолоор, БОАЖЯамны мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж тус тус батлуулаа.





3

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд ойн менежментийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар шинэчлэн боловсруулж, хавар, намар мод тарих өдрүүдийг зохион байгуулж, аймгийн хэмжээнд **336,000** мянган мод бутыг тарьж ногоон байгууламжийн хэмжээ өмнөх оноос **35 га-аар** нэмэгдлээ.





4

Улсын төсвийн хөрөнгөөр тал хээр говийн бүсийн хамгаалалтын ойн зурвас байгуулах ажил Баян-Өндөр суманд 10 га, Баруунбаян-Улаан суманд 8 га, Баянгол суманд 8 га тус тус хийгдэж, аймгийн хэмжээгээр ойжуулалт 43 га, байгалийн сэргэн ургалтад туслах ажил 15 га, ойн зурвас 40 га- хийгдлээ.





5

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй мод үржүүлгийн газруудыг үйл ажиллагааг дэмжиж ажилласнаар 20 гаруй нэр төрлийн 5.7 сая орчим тарьц суулгац ургуулснаас ирэх онд ойжуулалт, цэцэрлэгжүүлэлтэд шилжүүлэх боломжтой 2-с дээш настай 1.2 сая тарьц суулгацын нөөц бүрдүүлсэн.





6

Улс, орон нутаг, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр ойн сан бүхий газруудад нийт 31 мянган га талбайд ойн хортон устгалын ажил хийгдлээ.

2023 он 6 сарын 6 өдөр





7

Аймгийн хэмжээнд уст цэгийн тоо бүртгэлийн ажлыг амжилттай зохион байгуулж, тооллогын дүнгээр Өвөрхангай аймагт нийт давхардсан тоогоор 243 гол горхи, 1019 булаг шанд, 110 нуур цөөрөм, 2246 худаг, 10 услалтын систем, 11 хөв цөөрөм бүртгэгдсэн байна.

2023 он 6 сарын 16 өдөр





8


Аймгийн хэмжээнд 33 булаг, шанд рашааны эхийг хашиж хамгаалан Нарийнтээл сумын нутагт 1 хөв цөөрөм байгуулаа.





9

Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар Хужирт сумын халуун рашааны хэрэглээ, чанарыг хянах зорилгоор рашааны мониторингийн цооногт усны түвшин, температур хянах зориулалт бүхий **TD-Diver Datalogger** суурилуулж www.groundwater.mn улсын нэгдсэн системд холбуулаа.





10 |

Байгальд ээлтэй хандлага, зөв дадал, шийдлүүдийг танилцуулах, ногоон нутагт тулгамдсан асуудал, зорилтыг хангах зорилгоор иргэд олон нийт, өсвөр үеийнхэнд зориулж 19 суманд 35 удаагийн сургалт, 7 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж 5100 иргэн хамрагдаж, Хужирт суманд “Эко анги” тохижуулж, өсвөрийн байгаль хамгаалагчдыг бэлтгэх зорилгоор 20 удаагийн сургалт, “Эко клубүүдийн чуулга уулзалтыг зохион байгуулж 3200 гаруй хүүхэд хамрагдсан.

2023 он 6 сард өгөгдсөн мэдээ





11

Ан амьтдыг хамгаалах зорилгоор 15 сумын 94 цэгт 5000 боодол өвс, 8 тонн хужрыг нэн ховор болон ховор амьтад болох аргаль, янгир, халиун буганд тавьж өгөх ажлыг холбогдох сумдын ЗДТГазар, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Байгаль хамгаалагч, нөхөрлөлийн гишүүдтэй хамтран хийж гүйцэтгэсэн.





12

Идлэг шонхор болон бусад махчин шувуудыг өндөр хүчдэлд цохиулж эрсдэхээс хамгаалж, Баян-Өндөр суманд 100 ширхэг, Тарагт, Хайрхандулаан чиглэлийн ЭБЦТСтанцын 10 квт шугмын дагуу 20 ширхэг, Хархорин суманд 50 ширхэг, Гучин-Ус сум 30 ширхэг, Хужирт суманд 140 ширхэг, нийт 340 ширхэг суудал хийж шаардлагатай газруудад байршууллаа.


2023 он / 6 сард / 12 дүгээр / нэгдүгээр / сар





13

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Гучин-Ус, Төгрөг, Богд, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Хайрхандулаан, Уянга, Зүүнбаян-Улаан, Хужирт, Бат-Өлзий сумдад дотоод хяналт шалгалт зохион байгуулж, 2023 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн ажил болон 2024 оны орлого арга хэмжээний төлөвлөлт, байгаль орчны төсөв мэдээллийн сангийн программын ашиглалтад хяналт үнэлгээ хийж, мэргэшил арга зүйгээр хангаж зөвлөн туслах ажил зохион байгууллаа.





14


Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, шат дамжлагыг бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх хүрээнд ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гүн өрмийн худаг гаргах зөвшөөрөл, усны мэргэжлийн байгууллагын эрх олгох дүгнэлт, аймгийн Засаг даргын тодорхойлолт зэрэг 5 төрлийн үйлчилгээг цахимжуулж, "E-MONGOLIA" СИСТЕМД-а шилжүүллээ.

2023 он 6 сарын 14 өдөр

e mongolia
ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ПОРТАЛ

**ЦАХИМ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
НЭГДСЭН СИСТЕМ**

www.e-mongolia.mn





15

Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах үйл ажиллагааг дэмжих хүрээнд Өлзийт, Тарагт сумд орон нутгийн төсвийн 9,5 сая төгрөгөөр хоёрдогч түүхий эд пресслэх төхөөрөмж худалдан авч хоёрдогч түүхий эд бэлтгэн нийлүүлэх боломжтой болж аймгийн хэмжээнд 14 сум хоёрдогч түүхий эд пресслэх 20 төхөөрөмжтэй болсон.

2023 он / 6 сард / 15 дүгээр тал





16

Аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 сарын 30-ны өдрийн хурлаар аймгийн аялал жуулчлалын бүсийг шинэчлэн тогтоолоо.

2023 он 6 сард өдөр нэгдэл





17

Гар аргаар ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж нөхөн сэргээгдээгүй орхигдсон 86.4 га талбайд тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд болон бичил уурхайн нөхөрлөлүүдээр техникийн нөхөн сэргээлт хийлгэв.

- Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд: техникийн нөхөн сэргээлт 85.07 га, биологийн нөхөн сэргээлт 31.5

- Эзэн холбогдогч нь тодорхойгүй нөхөн сэргээгдээгүй орхигдсон талбайд: техник 84.6 га

- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан карьерын талбайд: техник 34.02 га





18

Байгаль орчны хамгаалах журмын эсрэг нийт 90 зөрчлийн гомдол мэдээллийг шалган шийдвэрлэж 78 зөрчилд 51.7 сая төгрөгийн торгууль оногдуулж, байгальд учирсан хохирлын 116.125.000 төгрөгийг нөхөн төлүүлж, эд мөрийн баримтаар хураан авсан 720 ширхэг, 1291 кг, 4.4 м/куб эд зүйлсийг хураан зохих журмын дагуу шийдвэрлэлээ.





19 |

Онги, Таац голын урсац бүрэлдэх эх бүхий Уянга, Нарийнтээл сумдын нутагт орших “Хангайн нуруу”-ны салбар уулсын үзүүр төгсгөл хэсэг, Баруунбаян-Улаан, Богд сумдын нутагт орших “Зүүн богд уул”-ын нийт 154.170 га тус тус байгалийн нөөц газрын ангиллаар Улсын тусгай хамгаалалтад авах тухай саналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж тусгай хамгаалалтад авах санал уламжлах тухай тогтоолыг Засгийн газарт хүргүүлсэн.

